

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255018>

**ҮГЭН НААДГАЙ “ДЭМБЭЭ”, ТҮҮНИЙ ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ОНЦЛОГ,
УТГА БЭЛГЭДЛИЙГ ТОДРУУЛАХ НЬ**

С.Чулуунпүрэв

Түлхүүр үг: Айраг найр, айргийн наадгай дэмбээ, дэмбээний гуншин, дэмбээний цээр, дэмбээний утга бэлгэдэл, маргаан мэтгээний аман зохиол.

Оршил

Айраг цагаа дэлгэрсэн зун намрын цагаар монголчуудын найр наадам мөн дэлгэрч, мал аж ахуйн ажлаа дуусгасны хойно оройдоо “айрагдах” хэмээх нэгэн сайхан зугаа үүсгэнэ. Айраг найр бол бол зөвхөн наргиан цэнгээний зүйл биш, айл саахалт, нутаг хошууны хүмүүс эвсэг найрсаг, эргэн уулзах баяр жаргалтай аж төрөхийн нэгэн хэсэг болдог юм. Айраг найрыг ихэвчлэн сүү сааль элбэгтэй жил буюу хөхүүртэй айргаа дундлан ууж чадахаа больсноор айргийн хөрөнгө ихдэж, хатууран ахрах болоод ирмэгц айргаа дундлах, хөрөнгөө багасган тааруулах үүднээс хийдэг. Айраг найрын ёсонд айл саахалт, гол довын хүмүүс хуруу, дэмбээ, алгирмаа зэрэг зөвхөн айргаар үүтгэдэг олон янз наадгай үүсгэн наргиж цэнгэдэг заншилтай.

Ш.Гаадамба, Х.Сампилдэндэв нар (1988) “Монгол ардын аман зохиол” нэрээр аман зохиол судлалын онолын ном бичихдээ “Ардын жүжиг наадам” бүлэгт зан үйлийн жүжиг наадам, тоглоом наадмын жүжиг наадам, уран сайхны жүжиг наадам гэж; Х.Сампилдэндэв (1988) “Ардын жүжиг наадмын аман зохиол” эмхэтгэлдээ зан үйлийн харилцаа шүлэг, тоглоом наадмын харилцаа шүлэг, харилцаа дуу гэж ангилаад, тоглоом наадмын хэсэгт нь хуурчдын цэц булаалдах үг, хүүхдийн дайралцаан, сүмбэр уул, дунд хуруу олох, асуух нурууны үг, дэлүү, цэцэн хүүхэд, тарвагацах, ес хэлэлцэх үг зэрэг тоглоом наадмын үгийг багтаажээ. Г.Нандинбилиг, С.Дулам нар (2020) жүжиг наадмын аман зохиолыг зан үйлийн жүжиг наадам, тоглоомын жүжиг наадам, уран сайхны жүжиг наадам гэж ангилаад тоглоомын жүжиг наадамд зан үйлийн тоглоом, үгийн наадам, хуруу гарын наадам, хөдөлгөөнт наадам гэсэн зүйлчлэл үүсгэхдээ өмнөх судлаачдын ангилал зүйлчлэлийг арай нарийвчлан задалж үзсэн байна.

Бидний төрөл зүйлийн онцлог, утга бэлгэдлийг тодруулахыг зорьж буй дэмбээ наадгай нь зөвхөн айраг цэгээгээр үүтгэж, айраг найрын зугаа цэнгэл үүсгэдгээрээ монголчуудын адуу дагасан айраг цэгээний соёлын айд багтах агаад аман зохиолын нэгэн төрөл зүйл болохын хувьд Г.Нандинбилиг, С.Дулам нарын ангилал, зүйлчлэлээр бол жүжиг наадмын аман зохиолын дотор үгээр наадгайлан тоглодгоороо үгийн наадам, хоёр хүн хуруугаа таалцан наадгайлж буйгаараа хуруу

гарын наадам, харилцан дайралцан мэтгэлцэж байдгаараа маргаан мэтгээний жүжиг наадамд хамаарч буй мэт ажээ.

Гэвч аман зохиол судлалын дээрх бүтээлүүдэд хуруу дэмбээг аль нэгэн төрөл зүйлд нь багтаан авч үзсэнгүй. Харин Өвөр Монголын судлаач Оч, Цэцэнгоо, Хөгжих, Хүүдагул, Эрдэнэбилэ нар (2015) “Монгол аман зохиолын удиртгал” номдоо тоглоом үгийн мэдэгдэхүүн гэсэн нэгэн хэсэгт зугаа үг, шүүлцээний үг, хуруу зэмэлцэх үг, худалдах үг, хэл боловсруулах үг гэсэн зүйлчлэл үүсгээд, “наадам тоглоомын зан үйлтэй холбогдон, түүний ёс журмыг тодорхойлон, шүүгдсэн этгээдийг егөөдөн шоглож, хур хөгжөөн нэмэхэд зориулагдсан уран үгсийг шүүлцээний үг” (Оч ба бусад, 2015:156), “Монголчууд архидан хөхрөлдөх үед хөөр хөгжөөн нэмэхээр хуруу зэмэлцэн гаргах, хуруутайгаа зохицуулан ая зантай уралдан хэлдэг үгийг хуруу зэмэлцэх үг гэдэг. Энэ нь мөнхүү наадам тоглоомын шүүлцээний үгийн нэгэн төрөл мөн” хэмээн тус тус тодорхойлж, “төв эрхэмсэг хурим ёслолд монголчууд ерөөс хуруу зэмэлцдэггүй бөгөөд үе алсран хоорондоо хуруу зэмэлцэхийг цээрлэдэг” (Оч ба бусад, 2015:158-159) болохыг тэмдэглэжээ. Энд жишээлэн авсан “гардаг үг битүү, гарын ганц, хайчийн хоёр, харш үг гурав, тэгш дөрөв, үзэмжит тав, өрөөл зургаа, найрын долоо, навчин найм, дэгээ ес, дэлгэ арав” гэсэн хуруу зэмэлцэх үгс нь дуутай хуруу, аравдах наадгайн үгс бөгөөд дэмбээ бол энэ тодорхойлолтын хувьд хуруу зэмэлцэхийн нэгэн төрөл мөн болно. Иймд бид дэмбээг жүжиг наадмын аман зохиолын доторх үгийн наадам, хуруу гарын наадам, маргаан мэтгээний жүжиг наадмын аль алиных нь шинжийг агуулж, үгээр наадан маргаан мэтгээн үүсгэж, хуруу гараа зэмэлцэн наадгайлдаг олон шинжийг нь бодолцон энэхүү өгүүлэлдээ үгийн наадгай дэмбээ хэмээн тодорхойлов.

Жүжиг наадмын аман зохиолын хүрээнд хамаарах зарим нэг зүйлсийг зүгээр нэг зугаа цэнгэлийн зүйл гэж үзэн дутуу анхаарч, төдий л сонирхон судлалгүй орхиж ирсэн нь ажиглагддаг. Үүнд, даалуу тоглоомын хүрээнээс бий болсон даалууны гуншин, адуу дагасан айраг цэгээний соёлд шингэсэн ардын аман наадмын нэг дэмбээ зэргийг нэрлэж болох бөгөөд бид энэ удаад дэмбээний үгийн наадам, зан үйлийн онцлог, аман шинж зэрэг төрөл зүйлийн онцлогийг судалж тодруулах зорилго тавьсан юм.

Дэмбээний талаар тухайлан судалсан өгүүлэл, судалгаа ховор авч уран сайхан, утга, зохиолын төрөл зүйл, урлаг судлалын сурвалж, судалгааны дотор ая дангийн талаас нь цухас өгүүлж өнгөрснөөр тааралдаж байна. Тухайлбал, Д.Нацагдорж 1901 оноор үйл явдлыг эхлүүлэн өгүүлсэн хэлбэрээр 1934 онд бичсэн “Хэлхээгүй сувд” туужид “...наргианы ид болохуй яа тунаа хийх болж, Сумьяаг цохлох дор ... гэрийн эзний эхнэр Мядагмаагаас эхлэн хуалж, хуучин шинэ алиныг ч торох үгүй гаргаж” (Жачин, 2016:248-249) байдгаар бичсэн бий. Эл зохиолд хуучин гэдэг нь хөгшин даглаа, шинэ гэдэг нь хуа дэмбээг хэлж буй бололтой байдаг. Мөн 1942 онд бүтээсэн “Сүхбаатар” (1942:09’00”-10’10”) уран сайхны кинонд хөгшин даглаагаар хуалж гардаг билээ. Телевиз, сонины төрөлд “Соёлын боловсролыг түгээх төв” НҮТББ бүтээсэн “Монголын уламжлалт тоглоом наадгай” баримтат кино цувралд “Дэмбээ” (2016) хэмээх нэгэн бэсрэг анги бий бол Д.Цэрэннадмид (2022) “Дэмбээ хэмээх наадаан” нийтлэлийг “Зууны мэдээ” сонинд нийтлүүлжээ.

Г.Бирваа (1989) “Монгол ардын аман аялгууны тухай товч өгүүлэх нь” өгүүлэлдээ “Манай ард түмэн тоглож наадахдаа ая эгийг үүсгэн байдаг нэгэн онцлогтой билээ. Жишээ нь, даалуу тавихад мод бүрийг зохицсон үгээр дуудах аялга, оньсого таалцан хожигдоход худалдах үгээ хэлэх аялга, маш түргэн хэмнэлтэй цэцэн хэллэгээр хуруугаа таалцаж буй дуутай хуруу гаргалтын сонин аялга зэрэг тоглоом наадмын олон дуудлага аялганууд байдаг. Аялга цаашид

хөгжиж ардын дууны уянгын намуу дөлгөөн аяар (малхийдэх) буюу зохицсон чамин чимэглэлтэй тоог хэлж тэмүүлсэн хэм хэмнэлтэй сонин гоё хүүрнэлийн аяар хурууны тоо таалцах, даглаадах, дэмбээдэх ...зэрэг тохирч зохицсон аялгуу зохион тоглоом наадамдаа хэрэглэж иржээ. Энэ нь тоглож буй тоглоом наадмаа улам хөгжилтэй болгон уйдахгүй байлгах, тоглолтын явцад гарч болзошгүй хор шар хөдлөх хүний сэтгэлийн хөдөлгөөнийг уран аялгуугаар зохируулна.” (Бирваа, 1989:129) гэжээ.

Монголчуудын хурим найр эхлэхдээ найрын даргын удирдлага дор төрт ёсны тогтсон уртын дуутайгаар, хатуу чанд дэгтэйгээр явдаг ба тэр дэгтэй найр өндөрлөхөд найрын дарга суудлаасаа огцорч, нийтийн ёсоор үргэлжлэхдээ завхай дуу, хуа дэмбээгээр хөгжин цэнгэж, найр задгайрдаг ёстой. Найр задгайрах нь дэг ёс суларч авахаас гадна найрт оролцогчид айраг сархдадаа халж хөгжин ааш аяг ч задгайрах үестэй таарах буюу. Мөн найрын дэг ёсоор заавал тогтоох ёстой дугараа хундаганууддаа тулж дүүрсэн үе таардаг ба дэмбээ дэмбээ нь хурууг бодоход удаан хугацаагаар тогтож тоглодог бөгөөд ая аялгуу үүсгэн нааддагаараа уусан айргийг сайтар шингээдэг онцлогтой наадгай билээ. Иймд найр задгайрахад тунаа хийх, найрыг удаан үргэлжлүүлэхэд дэмбээ үүсгэх нь таардаг учиртай ажээ.

Дэмбээний гарал үүслийг аяны хувьд нэлээд эртний гаралтай, Хүннүгийн үед хуруу гараар нааддаг ийм наадгай байсан мэтээр судлаачид тэмдэглэдэг авч тодорхой баримт нотолгоотой зүйл байхгүй байна. Ж.Дорждагва бээр “*Хуа бол Монголын биш, Хятадын юм. Урьд бидний багад хотод нүүсүүдийн хятад улс цагаан сараар үдэш дуулаад, хуалаад л наргидаг. Манайхны даачаа гэдгээр их хуална. Дуугаар бас хуалж л байдаг*” гээд “*харин дэмбээ бол монгол цэргийн юм гэж театрт нарийн бичгийн дарга хийж байсан харваач өвгөн Ишчогдов Автономитын үед¹ цэргүүд хийх ажилгүй их дуу гаргадаг байсны дотор дэмбээ гаргасан бололтой хэлснийг өгүүлжээ. Түүнчлэн иеэзэрмаа хуа бол хуаны хамгийн том хуа нь бөгөөд түүнийг хуалахдаа үс шанх, хөмсгөө илж засаж байгаад хоёр гараараа нэлээд хүндлэнгүй маягаар ханддаг*” (Бадраа, 2005:153-155) байснаас гадна “хятдууд дуугаар хуалж байсантай адил монголчууд ч ардын богино дууны аянд тохируулан “Цагаан шаазан”, “Хөх торгон цамц”, “Баян сүм” зэрэг дууны аяар хуалдаг” (Дуламсүрэн, 2020:30) байсан аж. Ж.Бадраа (Бадраа, 1998:68) хуруу таах энэ тоглоом нэлээд эртний гаралтай бөгөөд монголчуудын бодлого тааврын нэг зүйл юм хэмээгээд ая эгшгийн тухайд харьцангуй эрт үеийн гэж үзэж болох нэг давхар аяар “хөгшин даглаа”-г хуалдаг, хоёр давхар аятайд “Хөх торгон цамц” дууны аяыг хэрэглэдэг, хөнгөн хөгжүүн гурван давхар аяар дэмбээ нааддаг гэжээ. Ингэж олон янзаар хуалж дэмбээддэг байснаас өдгөө гагц Алгирмаа дууны аяар дэмбээдэх буюу алгирмаадах л үлдэж хоцорсон байна.

Харин хуучин цагт “хөгшчүүл дэмбээг хятад гаралтай хэмээн наадуулах төдий л дуртай байсангүй” (Өлзийсайхан, 2018:5). “Гүүний айраг исгэх уламжлалт арга технологи”-оор Монгол Улсын Соёлын биет бус өвийн 2021 оны шилдэг өвлөн уламжлагч болсон Д.Гүндэгмаа “*Манай өвөг эцэг дэмбээг Хүрээнд хятдууд, хоригдлууд хуалдаг байсан, “хувхай дэмбээ” гээд их дургүй. Дамаан “атган бооноо” гэж хоосон атгавал боож үхэх шахдаг сан*”² гэж өвөг эцэг Шоох Цэвээн гэгч хүнээс үзэж дуулж сонссоноо хэлж байснаас үзэхэд хуа даглаанд хятад үг оролцдог

¹ Монголын өөртөө эзэрхэх автономит засгийг эвдэж, Дундад Иргэн Улсаас цэргийн дэглэм тогтоосон 1919-1921 оны хоорондох зурвас үеийг хэлж байна.

² Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Батхаан багийн малчин, 1957 онд төрсөн, тахиа жилтэй, 68 настай Дашзэвэгийн Гүндэгмаа 2025 оны 8 дугаар сард нийслэлийн Налайх дүүргийн Тайж хайрхны бэлд болсон “Нүүдэлчин” соёлын наадмын үеэр ярьсан ярианаас.

учир монголчууд тийм ч таатай ханддаггүй байсан бололтой. Харин хятад соёлын нөлөө ихээхэн туссан хүрээ соёлд гоёчилж хээнцэрлэх ёсны үүднээс хуа дэмбээг найр наргианы хөгжөөн цэнгэл болгон ихээхэн дэлгэрүүлж байжээ. Мөнхүү “Хоосон дэмбээ хоригдлын зугаа”³ гэж айраг цагаагүй хоосон дэмбээдэхийг хатуу цээрлэдэг нь хүрээний төдийгүй сүүл цагийн шоронгийн хоригдлууд ч бүтэн цайг олон цагаар буцалган болгосон “баавар” хэмээх өтгөн хар цайгаараа зугаа үүсгэн дэмбээдэж, уйдаагаа гаргадаг байснаас үүдэлтэй хэлц хэллэг, заншил ёс бололтой. Хэдий дэмбээний гарал үүслийг яг таг тодорхойлон хэлэх боломжгүй боловч монголчууд гаднын аль ч соёлыг болов монголжуулж өөриймшүүлэн авдаг ёсоор өөрийн ёс ёслол, хорио цээрийг баримталж, утга бэлгэдлийг бий болгосноор бид үгийн наадгайн энэхүү төрөл зүйлийн онцлогийг тодруулан үзэх болно.

Өгүүлэл

1. Дэмбээний дүрэм журам ба айраг ууж шингээх өгүүлэмжийг тодруулах нь

Юун түрүүн дэмбээ тоглоомыг хэрхэн нааддаг болохыг өгүүлэхэд, хоорондоо дэмбээдэж буй хоёр хүн хоёр биеийнхээ баруун гарын арван хурууг нийлүүлэн тааж, тааж авсан оноогоо зүүн гарын хуруугаар дарж тэмдэг болгоод, тоо дөрөв болоход хуруугаа задгайлан цацах, тавих буюу энэ нь хожил ойртсоны дохио болж, ахин нэг тоо авч, тав болсноор хожно. Жишээлбэл, өөрөө гурван хуруу гаргахдаа өрсөлдөгч таван хуруу гаргах байх гэж тооцоолбол, нийт найман хуруу болохыг тааж, “Найзын найм аа” гэх гуншныг аялгуулан хэлж тоглоно.

*“Дэмбээ манан даа
Дөрвөнгийн дэнсээ холдоо байна
Долоод нь товгор
Гурвангийн гундан
Ганцхан эрхий
Дэмбээ авлаа би
Таваар нь таавал яаж байна хө
Найзынх нь найм аа
Еөгөөд нь хангай
Хоёроор нь холбоё
Дэмбээ муу юм чи...”*⁴ гэх жишээгээр дэмбээднэ.

Дэмбээдэж эхлэхдээ “Дэмбээ сайн байна уу?”, “Дэмбээ мэдэх үү хө?”, “Дэмбээ манан даа”, “Дэнжин гуай бандан/вандан даа”⁵ гэж мэнд мэдэх, өөрт хожил дуудах, эс бол цаад хүнээ сайн мууг нь асуух, егөөдөн хурцлах маягаар дуунд “Зээ татах”-ын адил өргөлтөөр эхлээд, жишээлэхэд “Таваар нь таана аа” гэж эхний хурууг гарган болзошгүй тоог хэлж, тэрхүү таах оролдлого ямар болсныг “Таажээ хө, мөн байна аа, авчээ би, холдоо байна, таньсангүй ээ, чиний тоо” гэж таасан эсэхээ дүгнэн нэгэн зогсоц аялгаар хэмнэл тэгшитгэж, араас нь гурван удаа таавар тоогоо хэлснээр мөн “Дэмбээ манан даа” гэх юм уу, энэ удаагийн таасан үе айзам дээр хэрхэн дэмбээдсэн явцыг “Дэмбээ... хожих нь ээ би, хожигдлоо би, авлаа

³ Мөн тэнд.

⁴ Зохиогчийн өөрийн дэмбээний жишээ бөгөөд цаашид ийм жишээг эшлэл зүүлтгүйгээр ашиглаж буй болно.

⁵ Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Батхаан багийн малчин, 1955 онд төрсөн, хонин жилтэй, эрэгтэй Даваажавын Дашзэвэгийн ярианаас. Соёлын боловсролыг түгээх төв, НҮТББ. (2016). *Монголын уламжлалт тоглоом наадгай: Дэмбээ*. Баримтат кино цуврал. <https://www.youtube.com/watch?v=C-b-9DWdbkc>

хө, солиорч байна би, муу юм чи, наашаа байна, сайн юм чи, муу байна би...” хэмээн дүгнэх, хожил өөрт дуудах, өрсөлдөгчөө өгөөдөх хэлбэрийн “Дэмбээ” гэх үгээрээ толгойлсон үг хэллэгтэй хашлага давтамж үүсгэн, нэгэн зогсцыг авснаар, дуугаар жишихэд нэгэн бадаг гүйцээд түрлэг юм уу дахилт явж, дараагийн бадгийг өмнөхийн адил үргэлжлүүлэн дэмбээдсээр аль нэг тал нь таван тоонд хүрч хожилцоно.

Хожигдсон нь айраг уух торгууль хүлээнэ. Торгуулийн айргийн их багыг тоглохын өмнө тохиролцох ба айраг найрын хуруу дэмбээ зэрэг наадгай нь аль болох өрсөлдөгч талаа айраг ууж чадахаа болих хүртэл олон хожиж, буулгаж авахын төлөөнөө наргиан хөгжөөн, хор шартай тэмцэлддэг учиртай. Ууж чадахааргүй байдалд тулахыг “*Боогдох*”, “*Шогнойх*” зэргээр хэлэх ба “боогдож шогнойсон бол “*Зоогийн сав зогсоолдоо хүрсэн*” ичгэвтэр байдлаа учирлаад, айргийн хул аяга, эсхүл хөхүүр архдыг үнсэж”⁶ шоглуулаад, буултаа өгч, айлын талын бах тавыг хангадаг заншилтай. Ингэж бууж өгөх ичгэвтэр байдалд хүрэхийг эс зөвшөөрвөөс торгуулийн айргаа уугаад, шингээж чадахгүй болбол бөөлжиж гаргахаас өөр замгүй болно. Уусан айргаа бөөлжиж орхихыг “*Тугаллах*”, “*Тугал гаргах*”, “*Тарлан тугал гаргах*” “*Цагаан тугал гаргах*”, “*Цагаан азарга булгиулах*” гэж ёгтоор шоглон нэрлээд, “*Хэнз тугал гаргалаа. Зуд болно. Тугалаа ногтолж аваад яваарай. Тэжээлийг нь өгөөрэй.*”⁷ гэх зэргээр мөн л ичээх нэрэлхээх болон ур ухаан дутаад хожигдож байгааг нь, уух шингээх чадал дутуу байгааг нь шүүмжлэхийн сацуу хуруу дэмбээндээ сайжрах, оюун ухаанаа хурцлах, малын буяныг шингээх чадал тэнхээ, гэдэс ходоодтой байхыг давхар давхар шаардсан, шар хорыг малтсан үгсийг шидэлж, маргаан мэтгээндээ буулган гаргаж байдаг болой.

Хэрэвзээ олонтоо хожигдсон ч торгуулийн айргаа ягталгүй ууж шингээж чадаж баймааж нь харин “*Түүтэй айлын гүзээтэй хүү юм*” гэж бахдан сайшааж байдаг талтай. Ер нь монголчууд их иддэг хүнээс илүү бага иддэг хүнд дургүй. Уг нь их иддэг хүнийг хоол хүнс барах хэмээн үл таашаам атал сайхан иддэг, сайн уудаг, даадаг гэж биширч бахдах, хүндлэн таашаах хандлагатай байна. Гэтэл бага иддэг хүнийг “*Зайлуул хоолонд муу юм*” гэж муушаан, “*Хулгана зурмын ходоодтой амьтан, буянгүй юм*” гэж үл таашаах тал байдаг. Үүнээс буянгүй юм гэж байгаа нь сонирхууштай бөгөөд ер нь дээшээ харсан савыг юм тогтоох буюу буян хишиг хурах гэж даллага хурайлгад хэрэглэх нь ч бий. Ингэхлээр их саванд их буян хурна, бага саванд бага буян хурна гэсэн шиг үзлээр хоол унданд сайн байна гэдэг бол сав сайтай юм гэж үзээд буян тогтох гэх ба угаас тарган цатгалан хүнийг буян тогтсон, нүүрийн буянтай, нүнжигтэй хэмээлцэнэ. Буяны тарга ч гэж байна. Их иддэг нь өл даах, бага иддэг нь өл даахгүй тул хээрээр гэр хийж, хэцээр дэр хийж явдаг нүүдэлчин ахуйд их идээч балгаач хүн их л зохимжтой юм. Монгол туульсад баатар эр:

Далан хүн дамжилж даашгүй

Далайн цагаан шаазанд

Дангийн хүйтэн арзнаас

Үзэсгэлэнтэй таван зуун хиа нараар

Дав даруй далан гурав хийлгүүлээд

Нэг нэгээр залгилаад суудаг (Бум-Эрдэнэ, 1986:24) гэхчлэн идэж уухаар нь

⁶ Булган аймгийн Рашаант сумын Хөгнөхаан нэгдүгээр багийн малчин, 1947 онд төрсөн, хулгана жилтэй Шаравжамцын Жадамбаас 2025 оны 8 дугаар сарын 08-ны өдөр Булган аймгийн Булган суманд тэмдэглэн авав.

⁷ Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын малчин, 1989 онд төрсөн, могой жилтэй Төрбатын Цэвээндагваас 2024 оны 9 дүгээр сард тэмдэглэн авав.

баатрын сүр хүчийг нэмж байдаг билээ.

Тэр ч атугай сайн ууж шингээхийн эсрэгцээ сайн бөөлжиж гаргахыг нэгэн төрлийн авьяас эрдэм мэтээр бахдан биширч байдаг тал ч бийг энд өгүүлбээс зохино. Гэрийн хоймроос үүдээр гартал бөөлждөг, тэгэхдээ завсарт нь нэг ч дусал газардуулахгүйгээр босго давуулдаг эрдэм чадалтай хүн байдгийг нутаг нутагт бахдан өгүүлж байдгийг орчин цагийн соёлт хүний ёсоор бодоход зэрлэгээ цэнгэл болгож, бохир заваанаа бахдал болгож буй мэт жигшин санагдууштай мэт боловч Долоон бурхан одны монгол домогт уламжилсан эр хүний анхдагч эрдэм чадлын нэгэн хэмжүүр нь энэхүү их идээч балгаач болон буцаан гаргадаг чадал хүч болохыг “*Би та нарыг гаргая гээд тэр хүн далайг нэг оочоод /балгаад/ ширгээчихжээ. Далай балгаад ширгээдэг нь хамгийн том ах болов. Далайн цаана гараад далайн усыг эргүүлж тавьчхаад явжээ.*” (Цэрэнсодном, 1989:56) гэж өгүүлсэн байдаг ба эл өгүүлэмжийг бид дараа жичид нь судлан өгүүлэх юм.

Дэмбээ наадмын эхний шат нь хуруудах гэж хэлж болох бөгөөд чулуу, шагай таалцах тоглоомын хэлбэрийг ашиглан хуруу таалцах буюу аравдах, дуутай хуруу гаргах гэсэн арай сонирхолтой хурууны төрлийг гаргаж ирснийгээ хуучин цагт сампингаар тоо бодохдоо ая дан оруулан байдаг шиг улам хөгжилтэй, наргианч, уйдахааргүй болгож аялгуулан таалцах болсноор ийм гурван үе шатыг дамжин үүссэн болов уу гэх магадлалтай байна.

2. Дэмбээний гуншин ба түүний онцлогийг тодруулах нь

Дэмбээний тоонууд тухай бүрнээ гуншин болох үгтэй байх ба дэмбээний нэгэн сонирхолтой төрөл Алгирмаад:

Алд алдын торгон хадгийг

Задалж сууна уу? Алгирмаа яа хө.

Аавын хүүгийн алтан дэмбээг

Захаас нь авхуулаад дуулах уу даа хө⁸

гэдэгчлэн түмэн янзын гуншин байж болохын захаас нь нийтлэг хэлэгддэг гуншныг цуглуулбал:

⁸ Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын харьяат, 1985 онд төрсөн, үхэр жилтэй, эрэгтэй Чинбатын Бат-Эрдэнээс 2010 оны оны 3 дугаар сард тэмдэглэн авав.

№	Тоо	1.Тоо+гуншин	2.Гуншин+тоо	3.Тоогүй гуншин	Нийтлэг
0	Атган, Таглан	Бооно оо, барья аа, сууна аа			Харья уу? авья аа, гэнэ ээ, байна уу? барина аа, хонгор оо, зээрд ээ, цэнхэр ээ, хөөрхөөн, хээр ээ, борлог оо, баян аа, сайхан аа
1	Ганцын, ганцаар нь	Эрхий, шовгор, нэг ээ, гаамай, ганбаа, борлог	Эрхийд нь ганц аа, Ганган ганц аа		
2	Хоёр /хоёрын, хоёронгийн, хоёрт нь, хоёрыг нь, хоёроор нь, хоёртой гэх мэтээр тийн ялгалд хувилна/	Холбоо, хонгор оо, хомбоо, зуузай, зээрд ээ	Холбоо хоёр оо	Холбоо зээрд ээ, холбон барина аа	
3	Гурав /хоёртой адил хувилна/	Гундан, гуайлна аа	Гунан гурав аа, Чөдрийн гурав аа	Чөдрийн тээг ээ, гурвалжин байна аа	
4	Дөрөв /хоёртой адил хувилна/	Дэнсээ, дэнжээ, дэргээ, бандан	Дөнгөж дөрөв өө, Дөгөөтэй дөрөв өө	Агтын туурай, дөрвөлжин бандан	
5	Тав/хоёртой адил хувилна/	Таана аа, таньжээ, танхай, тавина аа, таахай, мана аа	Таатайхан тав аа, талын тав аа	Тавлаг мөнгөө	
6	Зургаа / хоёртой адил хувилна/	Зурна аа, замилан, заана аа, зундаа	Зургийн зургаа, Зурвасын зургаа	Зургийн хөөрхөн, Зургийг нь дарья уу	
7	Долоо /хоёртой адил хувилна/	Доргино оо, домбоо, хоргой, товгор, донсоо			
8	Найм /хоёртой адил хувилна/	Нандиа, найз аа, бандгай, наргина аа	Найзын найм аа	Нандинд нь барина аа	
9	Ес /хоёртой адил хувилна/	Эрдэнэ ээ, -гуайн цэнхэр, ергинө, дэгээ		Еөгөөд нь хангай	
10	Арав /хоёртой адил хувилна/	Тэнэгэр, хангай, сайхан, арвай, дэлгэнэ, баян аа	Тэнэгэрхэн арав аа	Арвай хээр ээ, арвайн тэнэгэр ээ	

Хүснэгт 01⁹

гэсэн хэдэн төрлийн нийдэм хэллэг гуншин байна. Цуглуулсан эдгээр гуншнаас зарим чухал дүгнэлт, ангиллыг хийж болохоор байна.

Нэгдүгээрт, Дэмбээний гуншныг тооны хэлэгдэх байдлаар нь :

- тоо нь гуншныхаа урд /үндсэн хэлбэр/
- тоо нь гуншныхаа хойно /гуншин нь тоогоо шууд илэрхийлэхүйц байх ёстой. Эс бөгөөс булхай гардаг./
- тоо нь хэлэгдэхгүй /тоогоо шууд илэрхийлэхүйц гуншин/

⁹ Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын харьяат 21 настай Санжаагийн Нямдорж, Есөнзүйл сумын харьяат 22 настай Цэрэн-Адьяагийн Батхуяг нараас 2010 оны 3 дугаар сард тэмдэглэн авсан болон өөрийн гуншингаас.

Хоёрдугаарт, Гуншин зохиогдох арга хэлбэрээр нь:

- аялгаар холбох буюу толгой холбоцод захирагдан аялга зэрэгцүүлж сонсголонтой болгож гунших. /Энэ нь гуншин баяжих гол арга ба энэ талын гуншныг тоочвол тоймгүй./

- тэмдэг нэрээр өмнө хойно нь гунших /Ихэвчлэн адууны зүс зүсэм, бэлгэдэлт нэр байна./

- тухайн тоогоо шууд илэрхийлэхүйц мал аж ахуйн холбогдолт үгийн сангийн болон хэрэглээний үгс /Жишээ нь: чөдрийн тээг, есөнгийн эрдэнэ/

- тооныхоо араас тааврын шинжтэй нийтлэг үгсээр гунших гэж ангилж болохоор байна.

Мөн үүн дээр нэг сонирхолтой санааг хэлэхэд толгой холбоцод захирагдан сонсголонтой болгож гунших явцад монгол оньсого, даалууны гуншин зэрэгт элбэг байдаг “Монгол аман зохиол дахь зохиомол үгс” (Нямдорж, 2021)-ийн хэлбэр гарч ирдэг. *Хээр хэрмэлзэн, Хэрмэн чих сэрмэлзэн.* (Мойл) (Өлзийхутаг, 1966:56) *Ойн дойн хоёр* (олгой давсан) (Ловор ба Өлзийхутаг, 1990:279) зэрэг. Жишээ нь: *Ганцын гаамай, ганбаа, гурвын гундан, долоод нь донсоо, еөгөөд нь хангай* гэх мэт.

Мөн дэмбээний гуншингаас ажиглаж болох хэлний зүйн нэгэн сонирхолтой зүйл бол тооны араас гуншныг хэлэхэд тоо анхны үндэс хувилбараасаа ихэвчлэн тийн ялгалаар хувирч хэлэгддэг явдал юм. “*Ганц дээр харна аа, долоо домбоо, дөрөв дэнжээ...*” гэхчлэн цөөн хэдэн хувилбар тохиолдож болох ч энэ нь хэлэхэд нэлээд нийлц муутай, эв хавгүй сонсогддог. Заавал “*Хоёрын холбоо, гурвангийн гундаа, дөрөвт нь дэнжээ, тавийг нь таньжээ, зургаагаар зуржээ, долоотой домбоо*” гэх зэргээр ямар нэгэн нэрийн тийн ялгалын нөхцөлөөр хувилгаж, араас нь ихэвчлэн хамаатуулах нөхцөл орж байж, тэр тусмаа тоогоо “*хоёронгийн, наймангийн, тавангийн, гурвангийн...*” гэсэн хэлний зүйн зөв хувиллаас гажсан, өвөрмөц маягийн хэлбэр үүсгэж гэмээ нь аялахад амар, хэлэхүйд эвтэйхэн, мөн илүү сонсголонтой болж байгааг өгүүлэх эрхтэн, авиа зүйн үүднээс судалж үзвэл сонирхолтой юм.

Дээр дурдсанчлан толгой холбоцод захирагдан маш олон хувилбараар гуншин үүсэж болох ч мөн энэ хэлэхүйд амар, сонсголонтой байх зарчимд захирагдана. Жишээ нь, гуншин дан үетэй үгээр огт тохиолдохгүй гэж хэлж болно. Тохиолдвол араасаа “*нэг ээ, тав аа, найм аа, тээг ээ*” гэж уртатган дуудах эгшиг авч байгаа билээ.

Монголын жүжиг наадмын аман зохиолын дотор томоохон байр суурийг эзлэх уран сайхны төрөл зүйл бол харилцаа дуу бөгөөд тэр нь дуулалт жүжиг хөгжих хөрс суурь болсон гэж судлаачид үздэг. Дуулалт жүжгийн шинжтэй томоохон харилцаа дууны дотор залуу хосын хайр сэтгэл, ээдрээ адармааг өгүүлсэн Алгирмаа дууны аяар, мөн дууны бадаг шүлгээс авч, аялгуулан тоглодог хуруу гарын наадгай үүсгэсэн “Алгирмаа” хэмээх нэгэн төрөл айраг найрын дотор бий болжээ. Алгирмаадах янз маяг нь:

Алд алдын цэнхэр хадгийг

Задалж сууна аа, Алгирмаа яа хө.

Аавын хүүгийн алтан дэмбээг

*Захаас нь авхуулаад дуулах уу даа хө*¹⁰

Гурваар нь гуайлна аа

Тавын мана аа

Долоон товгор алгирмаа яа хө

¹⁰ Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын харьяат, 1985 онд төрсөн, үхэр жилтэй Чинбатын Бат-Эрдэнээс 2010 оны оны 3 дугаар сард тэмдэглэн авав.

*Зургаан хоргой
Хоёрын холбоо
Найзын найм аа алгирмаа яа хө
Жан жангийн торгон хадгийг
Задалж сууна аа, Алгирмаа яа хө
Заяанаас ургасан завхай дэмбээгээ*

Захаас нь авхуулаад дуулах уу даа хө¹¹ гэх жишээгээр Алгирмаа дууны намуу дөлгөөн ая дангаар аялан тоглодог. Энд гарч буй завхай хэмээх нь мөнгөн чимэглэлийнх нь тоогоор эмээлийг найман завхайтай, арван хоёр завхайтай зэргээр нэрлэдгээр гоё ганган, чамин хээнцрийг хэлэх үг мөн бөгөөд “захчин хокир дуун, дөрвөд, хотон магтаар дуун, торгууд харганайн дуун, баяд магтаар, шалиг, шагшуур дуун” (Сампилдэндэв, 1984:4) болон хүрээ дуу тэргүүтэй гэгэлгэн аятай, чамин хээнцэр богино дуунуудыг халхад завхай дуу хэмээн нэрлэдэг ёстой. Энэ ёсоор Алгирмаа завхай дууны төрөл болохоос гадна дэмбээ бол тэрчлэн хөнгөн гэгэлгэн аяар аялан наадах наадгай тул түүгээр завхай хэмээн тодотгож байгаа хэрэг бололтой. Тэгэхдээ Алгирмаа дуунд:

*Алд алдын торгон хадгийг
Задалж сууна аа, Алгирмаа хө
Анхны нөхөр Алтансүхтэй
Амьдралынхаа замыг холбосон доо хө
...Жан жангийн торгон хадгийг
Задалж сууна аа Алгирмаа хө
Заяаны нөхөр Алтансүхтэй*

Жаргалын замыг холбосон доо хө (Цэрэнсодном, 2011:302-303) гэснийг авч, уртхан шиг дахилт хашлага үүсгэн аялгуулж байдаг. Алгирмаа ийм урт дахилт давталттай бөгөөд аялгуу нь уянгалаг намуун, дэмбээг бодоход илүү сунжруу удаан байдаг тул бүсгүйчүүд хоорондоо, эсвэл эрчүүд бүсгүй хүнтэй алгирмаадах нь элбэг байдаг ажээ. Тоглох дүрэм журмын тухайд дэмбээдэхтэй бүхэлдээ ижил болой.

3. Дэмбээний гуншин ба цээрээс утга бэлгэдлийг тодруулах нь

Гуншнаас ажиглахад дэмбээ наадам нь адуутай найртай байхыг бэлгэдэж, адууны буян хишгийн даллага хурайлга болж байдгийг харж болно. Даллага хурайлга гэдэг бол эрхэмлэн хүндэтгэсэн зүйлдээ идээний дээж өргөн хишиг буяныг нь урин дуудсан аястай сацал мялаалгын нэгэн өвөрмөц хэлбэр юм. Дэмбээний гуншин дахь үгийн сангаас хөөж үзвэл адууны зүс зүсмээр гунших нь бий бөгөөд тухайн зүсмийн цаашлаад ер нь адууны буян хишгийг даллан дуудаж тогтоох гэсэн эрмэлзэл, өнгө аяс илэрхий тод байна. Ерөөс дэмбээний гуншин нь тодорхой утга төгссөн байдлаар илрэхгүй, харилцвар болохгүй мэт хэр нь дэмбээдэгч хоёр этгээдийн хандлага, шууд хэлээгүй санааг аяс аягаар илэрхийлж, холбоо тогтоож болж байгаа өвөрмөц онцлогтой.

Шувууны даллага, тэмээний даллага нь урин хаврын цагтай мэнд золгосны баяр болж, мал сүрэг өсөж үржихүйн буян хишгийг шарагч, харагч, цагаагчин, хуагчин ингэ, номхон зант, олби солби бөхт тэмээ; хулагч, алагч, хонгогч, буурагч гүүдээр төлөөлүүлэн дуудан хурайлсан (Сампилдэндэв, 1987:37-42) шинжтэй бол дэмбээ нь мөн адил дэлгэр зуны цаг ирж, айраг цагаа арвидсан цагаар адууныхаа буян хишгийг өөрт дуудан хурайлж, “Арвай хээр ээ, ганцангийн борлог, холбоо

¹¹ Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын харьяат 22 настай Ц.Батхуягаас 2010 оны 3 дугаар сарын 19-ний өдөр тэмдэглэн авав.

зээрд ээ, долоод нь хонгор оо...” хэмээн хээр, борлог, зээрд, хонгор адууныхаа баяжин дэлгэрэх /наймангийн баян аа.../ буян хишгийг “Дэмбээ адуундаа” хэмээн адуундаа даллаж буй цогц бэлгэдэл болох аж.

Чухамхүү ийн даллага дуудлагын шинжтэй юм гэдэг нь дэмбээний цээр ёсноос улам бүр нотлогдоно.

1. *Айраггүй дэмбээдэхгүй. Гүү хусарна.* Даллага хурайлга хийхдээ хүндэтгэн буй зүйлдээ идээний дээж өргөн, тахил тавиг болгон ёслол үйлдэх буюу. Гэтэл идээний дээж болж буй айраггүй дэмбээдэх нь тахил тавиг, өргөл хүндэтгэлгүйгээр адууны буян хишгийг даллаж буй хэрэг болох тул мэдээжээр буян хишиг үр төлөө харамлан гүү хусарна хэмээн цээрлэдэг учиртай байх нь. “Хоосон дэмбээ хоригдлын зугаа” гэж цээрлэдэг. Гүү баярлаж, унаганыхаа хөхөх сүүг эзэндээ өгсөндөө харамсдаггүй, баярладаг гэх тул саагч хийгээд татагч хүн саасан сүүгээ дамжилж явахыг эрхэмлэх ёсон бий. Түүн лүгээ ижил ““Бидний гаргасан сүү сааманд эзэд маань наргин цэнгээж байна. Улам их саам өгөх юм сан” гэж гүү урамшдаг. Бас айраггүй хоосон дэмбээдэхээр гүү малын сэтгэл уруугаа болдог гэдэг” (Цэрэннадмид, 2022:124).

0. *Алгаа доош харуулж дэмбээдэхгүй* дэлгэдэг нь алга урвуулах хэмээх цээрлэдгийн дээр даллага гэдэг нь гараар урин даллаж, тосон хурайлж буй учир доош харуулж дэмбээдвэл даллага хурайлга болохгүй буян хишиг уруугаа тогтохгүй болох, гараа савж дэмбээдвэл буян хишгээ зайлж займчиж буй мэт болж байгаа аж.

0. *Явуулын хүн дэмбээдэх цээртэй* байдаг нь нэг талаар зорьсон хэргээсээ өөр зүйлд сатаарах, наргиан наадам үүсэж хугацаа алдах, ажил хэрэг бүтэлгүй болох гэсэн болгоомжлол байхын сацуу нөгөө талаар харь нутагт өөрийн болоод нутаг хошууныхаа адуун сүргийн буян хишгийг даллан дуудаж буй цөвтэй тул ихэд цээрлэнэ билээ.

0. *Айраг цагаа байвч хайруу өвлийн цагаар дэмбээдэхийг цээрлэнэ.* Энэ нь бусад даллагын адил хамаг дэлхий төлжин шинэдэж, мал төллөн тараг айраг элбэгших дэлгэр хаврын цагаар даллага авахыг эрхэмлэн буй хэрэг ба эс бөгөөс мөн л адуун сүргийн буян хишигнээ онцын цөвтэй гэх буюу.

Ийнхүү дэмбээ наадам бүхлээрээ адууны буян хишгийн даллага дуудлагын бэлгэдэлт шинжтэй болох нь мэдэгдэж байгаа юм. Тиймдээ ч дэмбээний гуншны үг хэллэг огтын хамаа бусын үгс байдаггүй, нүүдлийн уламжлалт соёл, адуу малын ахуйн хэрэглээний үгс байна. Нэгэнт цээр ёсноос дурдсан хойно бусад цээр ёсноос дор өгүүлэхэд:

5. *Дэмбээний толгой дарахгүй.* Эрхий хурууг дэмбээний толгой хэмээн эрхэмлэх бөгөөд ямагт бусад хурууны дор дарахгүй, атгахдаа хүртэл долоовор хурууны гадна, дээр дардаг ёстой. Толгойг дарсан тохиолдолд цээр зөрчсөн, бууж өгсөнд шууд тооцож, торгуулийн айраг өгч цээрлүүлнэ. Энэ нь нэлээд байж болшгүй том алдас шиг зүйл болох бөгөөд даллага хурайлгын ёс алдаж цээр хийж байна ч гэж үзэж болмоор аж. Анхлан хуруудах үед аль аль талаас эрхий хуруу гарган мэндлэх ёсыг гүйцээж байдагтай энэ ёс холбогдож байна.

6. *Хадланд явж байхад дэмбээдэхгүй.* Дэмбээ нь хурууг бодвол хугацаа их шаарддаг, тул ажил уртасна, хугацаа сунана гэнэ. Мөн явуулын үед дэмбээдэхгүй гэдэгтэй ч ижил цээр байж болох талтай. Дэмбээ нь дуу хуурын адил ая аялгуутай, айраг архитай болсноор найр наргианы гол үүрэгтэй юм. Тиймээс ч зориудын тохироо бүрдсэн, ажил эмхэрсэн цагаар айл хотол, нутаг нугаараа, хонхор хоолойгоороо айраг нь элбэгшиж догшроход хүрсэн айлдаа цуглан хуруу дэмбээ, дуу хуур болно.

7. *Найр хурим, унаганы тамганы найр зэрэг баяр ёслолд дэмбээддэггүй гэдэг цээртэй.* Ерөөс монголчуудын зан үйл, ёс заншлын цаана ямагт тэнгэр онгодыг тахих, баясгах нэгэн утга бэлгэдэл ямагт дагалдан байдаг билээ. “Уламжлалт тоглоомд хүмүүний амьдрал, үйл ажиллагааг загварчилж, тэнгэр, лус савдаг зэрэг хийсвэр ертөнцийн дүрүүдийг бүтээж, тэдгээрийн нөлөө, ивээл өршөөлийг бэлгэдэх санаа ямагт зэрэгцдэг” (Нандинбилиг Г., 2024:17) гэж, “Монгол тоглоомын аман зохиол” номдоо Г.Нандинбилиг үзжээ. Найр хуримын тухайд ураг удмын тэнгэрүүдийг баясгах, тахих утгатай бол дэмбээний агуулга нь адууны тэнгэрийг баясгах, буян хишгийг хурайлах зоригдолтой байгаа тул хоёр зан үйл зөрчилдөхөөс сэргийлж, цээрлэн үзэж байх магадтай болно. Нөгөөтээгүүр хурим найр бол зан үйлийн олон агуулгатай бол, айраг найр нь ихэвчлэн зугаацан цэнгэх, наргиж хөгжих агуулга давамгайн учир тэр бололтой. Унага тамганы найранд дэмбээддэггүй нь мөн тийм учир холбогдолтой. “Намар гүү тавих, унага тамгалах үед дэмбээдвэл шуурга цасанд мал урууддаг гэсэн уламжлалт ёс бий” (Цэрэннадмид Д., 2022:124) гэсэн нь өвөл дэмбээддэггүй гэсэн цээрийн утгатай таарна.

4. *Дэмбээний маргаан мэтгээний шинжийг тодруулах нь*

Дэмбээний бас нэгэн гол шинж нь ардын маргаан мэтгээний цэц булаалдах аман зохиолын шинж юм. Аман зохиолын энэ төрөлд юуг багтааж болох вэ гэвэл сүй бэлэг хэлэлцэх үүдэн дарлагын үг, хуурчдын гартаах үг, оньсого худалдах үг, дайралцаа шүлэг зэрэг харилцан мэтгэлцэж цэц булаалдсан уран шүлэг үгсийг багтаан сонирхолтой нэгэн шинэ ай болгож болох юм. Хүүхдийн дайралцааныг жишээлэхэд “...хүүхдүүд хоорондоо хурдан сэтгэх чадвар, шүлэглэх авьяасаа сорилцон, сэц булаацалдах харилцаа шүлэг бөгөөд драмын элемент бүхий ээлжлэн харилцах жүжгийн хэлбэртэй...” (Гаадамба ба Сампилдэндэв, 1988:330) байхад дэмбээнд мөн л эдгээр шинжүүд яв цав байх ба жүжгийн элемент болохын тухайд ээлжлэн харилцах бус нэгэн зэрэг харилцаа үүсгэх өвөрмөц онцлогтой сонин зүйл юм.

Дайралцаанд “...цэц булаалдах учир зорилго, юугаар маргалдан мэтгэлцэх зэргээ тодруулан

Зээ хүү минь үнэхээр тийм үү дээ хө

Дайралцвал дайралцъя

Даалин хөөргөө тавилцъя

Хэлэлцвэл хэлэлцье

Хэт хутгаа тавилцъя гэсэн оршил хэсэгтэй...” (Гаадамба ба бусад, 1988:330) байхад дэмбээнд мэнд мэдэх, өөрт хожил дуудах оршил, дэмбээний хожуу үүссэн нэгэн сонирхолтой төрөл Алгирмаад

Цэн цэнгийн цэнхэр хадгийг

Дэлгээж сууна уу? Алгирмаа яа хө.

Аавын хүүгийн алтан дэмбээг

*Захаас нь авхуулаад дуулах уу даа хө*¹² гэсэн дайралцааны үг хэллэгтэй төсөөтэй оршил байна.

“...Дайралцаан нь нэгэнт хоёр хүүхдийн хоорондын уран үг, сэтгэх чадварын өрсөлдөөн учраас

“ - Зээ хүү минь үнэхээр тийм үү дээ хө

Зурмантайхан нүхэнд нь

¹² Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын харьяат, 1988 онд төрсөн, 22 настай, эрэгтэй Ц.Батхуягаас 2010 оны 3 дугаар сарын 19-ний өдөр тэмдэглэн авав.

*Зургаан салаа байна уу даа
Зулзган чиний цээжинд
Зургаан шүлэг байна уу даа
Гүн нуурын усанд нь
Гөлмөн үзүүр автаагүй
Гүйгээд ирсэн чам мууд*

Шүлгэн үзүүр автаагүй” гэх зэргээр нөгөөгийнхөө урнаар шүлэглэх чадварын хэр хэмжээ, цэц оюуныг сорьж тэнсэн, егөөдсөн үгс хэлдэг...” (Гаадамба ба бусад, 1988:330-331) бол дэмбээнд егөө гуншны зэрэгцээ *“Дэмбээнд муу юм чи, Дэмбээ хожих нь ээ би, дэмбээгээр барахгүй нь дүү”* гэж егөөдөж басамжлан, цацах тавихдаа *“Дэмбээ цаад руу чинь, дэмбээ адуунд нь...”* гэхчлэн айлгаж тэвдүүлэн байдаг. “Ер нь иймэрхүү өрсөлдөөн тэмцээнд дайрч басах, хор малтах үг хэлдэг нь хүчээ шавхан, оюунаа дайчлан уриалсан арга юм...” (Гаадамба ба бусад, 1988:331). Мөн хурдан буюу шогшоо дэмбээ нь маш хурдан сийрэг сэтгэхийг шаардана. Ерөнхийдөө дэмбээ бол сэтгэн бодох, тооцоолон тааварлах, хэл яриа, харааны хурд, авхаалж самбаа, заль мэх, анхаарал төвлөрөл гээд олон нарийн мэдрэмж чадвар шаардсан тоглоом наадгай болно.

“...Дайралцааны эхэнд *“Зээ хүү минь үнэхээр тийм үү дээ”* гэсэн үгийг тогтмол давтан хэлдэг нь нэг ёсондоо шинээр юу хэлэхээ санаандаа төлөвлөхийн тулд түр амсхийн бодох чөлөө гаргах буюу хэмнэл айзам үүсгэж буй...” (Гаадамба ба бусад, 1988:331) байхад дэмбээн дээр *“Дэмбээ манан даа”* юм уу дээр дурдсанчлан егөө үгнүүдийг таах тоо, гуншны өмнө хойно тогтмол давтан оруулж байгаа нь ч мөн адил үүрэгтэй юм. Ингэж дэмбээг маргаан мэтгээний сэц булаалдах аман зохиол гэсэн нэгэн сонирхолтой төрөл зүйлд багтааж болохоор байна.

Дүгнэлт

Энэ бүхнээс дүгнэж үзвэл, “дэмбээ” нь аман зохиолын амаар зохиогдож уламжлах жам ёсны хөгжлийн дагуу хөгжиж буй маргаан мэтгээний аман зохиолын нэгэн зүйл бөгөөд төрөл зүйлийн өвөрмөц онцлогийг монгол аман зохиолын дөрвөн шинжийн үүднээс судалж дүгнэвэл:

1. Дэмбээ нь дүрслэг шинжийн хувьд хэдий уран яруу биш боловч өөрийн өвөрмөц үгсийн сан, хэл хэлмэр, хэлбэр найруулгаараа ялгарч чадсан, аман зохиолын өвөрмөц нэгэн зүйл мөн бөгөөд аман шинжийн хувьд хуруу гарын уран хөдөлгөөнийг аялгуулан хэлэх ая дантай хавсран хоёр дэмбээчин нэгэн зэрэг бэлэн цэцлэн хэлж, үзэгч сонсогчдод үзүүлж сонсгох бүтээл болно.

2. Дэмбээ нь зан ааль, зан үйлийн шинжийн хувьд айрагтай найртай орчин ахуйд наргиа наадмыг үүсгэх зорилгоор зохиогдон уламжлах ба утга бэлгэдлийн хувьд бүхлээрээ адууны буян хишгийн даллага дуудлагын утгыг олж, адуутай найртай байхыг бэлгэдэн хөгжиж ирсэн нь дэмбээний үгсийн санд хийсэн ажиглалт болон цээр ёсны уламжлалаар нотлогдож байна.

3. Толгой холбоцод захирагдан сонсголонтой болгож гунших явцад монгол оньсого, даалууны гуншин зэрэгт элбэг байдаг зохиомол үгийн хэлбэр гарч ирж буй нь аман зохиолын зарим төрлийн сонирхолтой хэлбэржил юм.

4. Дэмбээг жүжиг наадмын аман зохиолын дотор хуримын сүй бэлэг хэлэлцэх үг, үүдэн дарлагын үг, хуурчдын гартаах үг, оньсого худалдах үг, дайралцаа шүлэг зэрэг харилцан мэтгэлцэж, цэц булаалдсан уран шүлэг үгсийг оролцуулан маргаан мэтгээний аман зохиол гэсэн сонирхолтой нэгэн шинэ айд багтааж болохоор байна.

Ном зүй

- Бадраа, Ж. (2005). *Их дуучны яриа*. Улаанбаатар.
- Бадраа, Ж. (1998). *Монгол ардын хөгжим*. Улаанбаатар.
- Бат-Ирээдүй, Ж ба Арьяасүрэн, Ч. (1999). *Монгол ёс заншлын их тайлбар толь. II боть*. Улаанбаатар.
- Гаадамба, Ш ба Сампилдэндэв, Х. (1988). *Монгол ардын аман зохиол*. Улаанбаатар.
- Дулам, С ба Нандинбилиг, Г. (2007). *Монгол ардын аман зохиолын онол-I: Аман яруу найраг*. Улаанбаатар.
- Дуламсүрэн, С. (2020). *Хүрээ дууны донж маяг*. Урлаг судлалын ухааны магистрын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар: МУИС.
- Бирваа, Г. (1989). Монгол ардын аман аялгууны тухай товч өгүүлэх нь. *Монголын хөгжим судлал*. Улаанбаатар.
- Жачин, Ч. (эмх.). (2016). *Дагдоржийн Нацагдорж: Зохиолын цоморлог*. Улаанбаатар.
- Захри, А.Г. Хейфиц, И.Е. (1942). *Сүхбаатар*. Монголын уран сайхны кино. <https://www.youtube.com/watch?v=fM3htE-2AxE>
- Катуу, Б. (эмх.). (1986). *Бум-Эрдэнэ*. Улаанбаатар.
- Ловор, Г ба Өлзийхутаг, Ц. (эмх.). (1990). *Монгол ардын оньсого таавар*. Улаанбаатар.
- Нандинбилиг, Г ба Дулам, С. (2020). *Монгол аман зохиолын онол-II: Хүүрнэн өгүүлэх аман зохиол, Жүжиг наадмын аман зохиол*. Улаанбаатар.
- Нандинбилиг, Г. (2024). *Монгол тоглоомын аман зохиол: дүр, бэлгэдэл*. Улаанбаатар.
- Нямдорж, Д. (2021). *Монгол аман зохиол дахь зохиомол үгс*. Улаанбаатар.
- Оч, Цэцэнгоо, Хөгжих, Хүүдагул & Эрдэнэбилэг. (2015). *Монгол аман зохиолын удиртгал*. Монгол бичгээс хөрвүүлсэн Б.Мөнхбаяр. Улаанбаатар.
- Өлзийсайхан, С. (2018). Монголчуудын айраг исгэх уламжлал. *Acta Historica Mongolica. Tom.XVIII., Fas.1-15*. Улаанбаатар.
- Өлзийхутаг, Ц. (эмх.). (1966). *Монгол ардын түмэн оньсого*. Улаанбаатар.
- Сампилдэндэв, Х. (эмх.). (1987). *Монгол ардын зан үйлийн аман зохиол*. Улаанбаатар.
- Сампилдэндэв, Х. (эмх.). (1988). *Ардын жүжиг наадмын аман зохиол*. Улаанбаатар.
- Сампилдэндэв, Х. ба Яцковской К. Н., (эмх.). (1984). *Монгол ардын уртын дуу*. Улаанбаатар.
- Соёлын боловсролыг түгээх төв, НҮТББ. (2016). *Монголын уламжлалт тоглоом наадгай: Дэмбээ*. Баримтат кино цуврал. Улаанбаатар.
- <https://www.youtube.com/watch?v=C-b-9DWdbkc>
- Цэрэннадмид, Д. (2022). Дэмбээ гэдэг наадаан. “Зууны мэдээ” сонин. 2022 оны 6 дугаар сарын 24. Баасан гараг. №124 (6856). Улаанбаатар.
- <https://www.polit.mn/a/95902>
- Цэрэнсодном, Д. (эмх.). (1989). *Монгол ардын домог үлгэр*. Улаанбаатар.
- Цэрэнсодном, Д. (эмх.). (2011). *Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг*. Улаанбаатар.

Хээрийн судалгааны эх сурвалж:

- Батхуяг Цэрэн-Адьяагийн, Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын харьяат, 1988 онд төрсөн, луу жилтэй, эрэгтэй.
- Бат-Эрдэнэ Чинбатын, Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын харьяат, 1985 онд төрсөн, үхэр жилтэй, эрэгтэй.
- Гүндэгмаа Дашзэвэгийн, Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Батхаан багийн малчин, 1957 онд төрсөн, тахиа жилтэй, эмэгтэй.
- Дашзэвэг Даваажавын, Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Батхаан багийн малчин, 1955 онд төрсөн, хонин жилтэй, эрэгтэй.

Жадамба Шаравжамцын, Булган аймгийн Рашаант сумын Хөгнөхаан нэгдүгээр багийн малчин, 1947 онд төрсөн, хулгана жилтэй, эрэгтэй.

Нямдорж Санжаагийн, Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын харьяат, 1989 онд төрсөн, могой жилтэй, эрэгтэй.

Цэвээндагва Төрбатын, Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Бөмбий багийн малчин, 1989 онд төрсөн, могой жилтэй, эрэгтэй.

Чинбат Жамбын, Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Бумбат багийн малчин, 1940 онд төрсөн, луу жилтэй, эрэгтэй.

Abstract

During the summer and autumn airak feasts, when there is an abundance of airak and milk, the Mongols engage in the playing of Dembé. This is a game that is played with the fingers and involves the repeating words in rhymes. The primary objective is to compel one's opponent to consume as much airak as possible. Dembe, being a type of oral folk art, has elements of humor, performance, and competition aimed at developing speech, dexterity, and quick-wittedness, when two opponents try to guess how many fingers the other will show and attack each other with rhymes. The article examines the genre of oral folk art known as Dembe, highlighting its varieties, genre characteristics, and symbolic meaning through its rhymes, rules, taboos, and rituals. This game is directly linked to the culture of horse breeding and airak consumption, and over time has become one of the rituals for accumulating wealth and ensuring the prosperity of livestock.